Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
03/09 дугаар албан бичгийн 1 дугаар хавсралт

# БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

| **НЭГ. Товч танилцуулга[2]** |
|---|
| Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгууллагын даргын 2024 оны А/16 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй, аймгийн Засаг даргаас томилогддог Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагаас орон нутгийн төсвөөс санхүүждэг, байгууллагууд албан хаагчийн тооноосоо хамааран 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ёс зүйн дэд хороогоо байгуулсан. Үүнд:<br>Аймгийн Байгаль орчны газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрууд тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан үйл ажиллагааг явуулж байна.<br>Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар байгууллагын даргын шийдвэрээр 7 хүний бүрэлдэхүүнтэй, Замын-Үүд сум ЗДТГ 5 хүний бүрэлдэхүүнтэй, бусад 12 сумын Засаг даргын Тамгын газар 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллага, нутгийн захиргааны нийт 20 байгууллага 3-7 хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж байгаа бөгөөд нийт 68 төрийн албан хаагч тус хороодуудад ажиллаж байна.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо 2025 онд хэрэгжүүлэх 12 заалт бүхий төлөвлөгөөг байгууллагын удирдлагаар батлуулан хэрэгжүүлэн ажилласан. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, дэд хороодын гишүүдийг чадавхжуулах сургалтыг тус төлөвлөгөөнд тусган батлуулж, тайлант онд төрийн албан хаагчдад 2 удаагийн ёс зүйн сургалт, чадавхжуулах ажлыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг, байгууллага, боловсролын болон эрүүл мэндийн салбарын нийт 107 ёс зүйн дэд хороо байгуулагдан үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байна. Дээрх сургалтуудад давхардсан тоогоор 300 гаруй ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамруулан ажилласан. |
| **ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар** |
| 2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]: |

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.
[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.
[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажилласан.

Тус төлөвлөгөөний хүрээнд сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулсан бөгөөд аймгийн 14 сумын хэмжээнд 683 төрийн албан хаагчийг ёс зүй, манлайлал, санхүүгийн сахилга бат, архив, сэтгэлгээний өөрчлөлтийн чиглэлээр зохион байгуулсан сургалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор хамруулсан. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 7 агентлаг байгууллага болон төрийн байгууллагын 356 орчим төрийн албан хаагчийг хамруулан ажилласан.

Тайлант онд Ёс зүйн дэд хороонд төрийн байгууллагын 5 төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гаргасан 3 өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2 гомдлыг харъяаллын дагуу шилжүүлсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбогдолтой 1 гомдол гаргагч нь өөрийн хүсэлтээр өргөдлөө буцаасан байна.

Төрийн байгууллагууд шинээр төрийн албанд орж буй албан хаагчдад чиглүүлэх, дадлагажуулах, сургалтыг Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлтэй болон байгууллагын Ёс зүйн дэд хороотой хамтран зохион байгуулан ажилласан. Тус сургалтаар шинээр батлагдсан төрийн албаны стандарт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль зэрэг эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, анхан шатны мэдлэг олгох агуулгатай сургалтыг зохион байгуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Тайлант онд томилох эрх бүхий албан тушаалтан буюу, нэгж, алба, тасгийн удирдах албан тушаалтны төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн тухай мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулсан.

Мөн “Сэтгэлгээний өөрчлөлт” сэдвийн сургагч багшийн 2, Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн, “Төрийн албаны манлайлал” говийн бүсийн зөвлөгөөнд 120 албан хаагчийг хамруулснаас ёс зүйн дэд хорооны 28 гишүүн, 15 удирдах албан тушаалтан, Төрийн албаны зөвлөлийн сургалтад 2 удирдах албан тушаалтныг тус тус хамруулсан.

Аймгийн Засаг даргын 2025 оны А/246 дугаар захирамжаар Дорноговь аймгийн удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнийг 2025 оны 1 дүгээр улиралд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд 115 удирдах албан тушаалтныг хамруулсан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөл болон аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх ёс зүйн дэд хороотой хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон төрийн албан хаагчийг соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, ойлголт, мэдээллийг өгч ажилласан.

Мөн сумдын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, нөхцөл байдлын талаар удирдах албан тушаалтнуудад мэдээлэл өгч ажилласан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Төрийн албаны зөвлөл, архивын ерөнхий газартай хамтран 21 аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн ажлын зохион байгуулалт”-ын улсын үзлэгт Дорноговь аймаг амжилттай шалгагдсан.

Тус хяналт шалгалтын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө батлагдан, урьдчилсан үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан 14 сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг байгууллага болон төсвийн байгууллагууд буюу нийт 153 төрийн байгууллагад урьдчилсан үзлэг зохион байгуулсан.

Тус ажлын хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 5 гишүүн орж ажилласан бөгөөд байгууллага бүрийн ёс зүйн дэд хороодын төлөвлөгөө, зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай

нэг бүрчлэн танилцаж, арга зүйн дэмжлэг үзүүлж, ажил сайжруулах зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасны дагуу тайлант онд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдэд 2 дугаар улиралд ажил дүгнэн, ажлын тайлан, гишүүдийн хуралдаанд оролцсон идэвх, оролцоо, ёс зүйн гомдолд ажилласан байдал зэргийг үндэслэн урамшууллыг олгосон. Бусад улирлуудад урамшууллыг олгоогүй бөгөөд аймгийн төрийн байгууллагууд ёс зүйн дэд хороодын гишүүдэд урамшуулал олгож ажиллаагүй болно.

| Гарсан үр дүн, ололт амжилт: | Бэрхшээл: |
| --- | --- |
| Аймгийн төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь гишүүн шилжин ажиллах, ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд байгууллагын хамт олны хурлаар дахин санал хурааж, ёс зүйн дэд хорооны гишүүнийг шинээр сонгон, байгууллагын даргын тушаал, шийдвэрээр хороог шинэчлэн байгуулж ажилласан.<br><br>Тайлант онд ёс зүйн дэд хороонд ирсэн төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой зөрчил, гомдол, мэдээлэл 3 удаа ирсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 1-ээр буурч, ёс зүйн зөрчил тогтоогдоогүй байна. | Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын 300 гаруй албан хаагч, хуулиар хүлээсэн болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлж, хэрэгжүүлж ажиллахаас гадна, байгууллагын ёс зүйн асуудлыг хариуцан сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, төлөвлөн, хэрэгжилтийг хангаж ажилладаг.<br><br>Мөн ёс зүйн асуудлаар гаргасан өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх, тайлбар авах, шалгах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.<br><br>Иймд хийж хэрэгжүүлж буй сургалт, мэдээлэл хүргэх, төрийн албан хаагчийг соён гэгээрүүлэх ажлыг үнэлэх, дүгнэх, урамшуулах, ёс зүйн дэд хороодын гишүүдийг сэдэлжүүлж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл байдал бүрдэхгүй, хэмнэлтийн хууль, эрх зүйн актын хүрээнд нэмэлт урамшуулал олгохгүй байгаа нь төрийн албан хаагч, ёс зүйн дэд хорооны гишүүнийг идэвх санаачилгатай ажиллах, шинийг эрэлхийлэх, бүтээмж гаргахад бэрхшээл учруулж байна.<br><br>Ёс зүйн гомдол хянан шийдвэрлэсэн шийдвэр нь ёс зүйн гомдолд холбогдогч этгээдүүдэд тааламжтай байдаггүйн улмаас шийдвэрийг эс зөвшөөрдөг. Иймд ёс зүйн дэд хорооны дүгнэлт шийдвэр, эрх бүх албан тушаалтны шийдвэр хууль хяналтын байгууллагад очиж шалгагддаг. Энэ шийдвэр нь зарим тохиолдолд унах тохиолдол гардаг. Иймд ёс зүйн дэд хорооны гишүүдийг гомдол хянан шийдвэрлэх дадлага сургалтыг үр дүнтэй зохион байгуулахгүй бол эрсдэл их гарах магадлал байна. |

| Санал: |
| --- |
| - Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороонд ажиллах гишүүдийн урамшууллыг жил болгон төсөвтөө суулгах чиглэлийг холбогдох эрх бүхий байгууллагаар дамжуулан үүрэгжүүлэх. Ингэснээр Ёс зүйн дэд хорооны гишүүдийн ажиллах идэвхи, санаачлага нэмэгдэнэ.<br>- Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхижуулах танхимын дадлагжуулсан сургалтыг үе шаттай мэргэжлийн байгууллага, сургагч багш нараар хийлгүүлэх.<br>- Орон нутагт ёс зүйн сургагч багшийг бэлтгэх.<br>- Монгол Улсын ёс зүйн хорооноос орон нутаг дахь улс төрийн албан хаагч нарт ёс сургалт, мэдээллийг тусгайлан хийх. |

**Шалгах хэсэг:**

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Томилох эрх бүхий албан тушаалтан

ХЗДТГ-ын дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ Б.Бат-Эрдэнэ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга
Салбар зөвлөлийн
Нарийн бичгийн дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ Н.Баттуяа /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ТЗҮХ-ийн ахлах мэргэжилтэн

/Албан тушаал/ /Гарын үсэг/ Б.Золжаргал /Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 сарын 05

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2025. оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
03/09.. дугаар албан бичгийн 2.. дугаар хавсралт

**БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ**
**"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"**

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо[1] | Хувийн жин[2] |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ) | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4] | | 1 | 1 | 10 |
| 2 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5] | | 1 | 0.5 | 5 |
| 3 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6] | 0,5 | 0.5 | 5 |
| | | | Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7] | 0,5 | 0.5 | 5 |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8] | 0,5 | 0,5 | 5 |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9] | 0,5 | 0.3 | 3 |
| **Хэсгийн оноо** | | | | **4** | **2.8** | **33** |
| 4 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ) | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)* | | 1 | 1 | 10 |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11] | | 1 | 1 | 10 |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12] | | 1 | 1 | 10 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **3** | **30** |
| 7 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ) | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13] | | 1 | 0.8 | 8 |
| 8 | | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өрөвдөл, гомдлын хувийн жингээр тооцно)* | | 1 | 1 | 10 |
| 9 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15] | | 1 | 1 | 10 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **2.8** | 28 |
| **Үнэлгээний нийт оноо, хувь** | | | | **10** | **8.6** | **91** |

**Тайлбар:**

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн баталсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТ-ЭРДЭНЭ

2025 оны ..02 дугаар сарын ..15..

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
# ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Гүйцэтгэх үйл ажиллагаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| 1 | "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын болон аймгийн түвшинд сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах. | ОНТ | Сургалт, сурталчилгаанд хамрагдсан албан хаагчийн тоогоор | 1,185 | 1,500 | Жилдээ | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, гаргасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх. | - | Гаргасан дүгнэлтийн тоогоор | 3 | 0 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | БТ | Байгууллагын сургалтад хамрагдсан албан хаагчдын тоогоор | 25 | 50 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 4 | Шинээр ажилд орсон ажилтанд чиглүүлэх 8 цагийн сургалтыг ТЗУХ-тэй хамтран зохион байгуулах. | - | Сургалт зохион байгуулсан албан хаагчийн тоогоор | 0 | Шинээр томилогдсон албан хаагчдад | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 5 | Байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох ажлыг ХШҮХ-тэй хамтран зохион байгуулах. | - | Дотоод хяналт шалгалтын тоогоор | 0 | 1 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 6 | Гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хүлээн авч, хянан шалгаж, шийдвэрлэх. | - | Хүлээн авч шийдвэрлэсэн гомдлын тоогоор | 3 | Үүссэн тохиолдолд | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 7 | Аймгийн төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, хуулийг сурталчлан таниулах цахим сургалт, видео хичээл, шторк бэлтгэх. | ОНТ | Бэлтгэсэн цахим сургалт, видео шторкын тоогоор | 0 | 1 | 3 дугаар улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо, АЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба |
| Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах | | | | | | | |
| 8 | Байгууллагын ёс зүйн дэд хороодын гишүүдийн цахим хаягийг бүртгэлжүүлэх | - | Бүртгэлжүүлсэн байгууллагын тоогоор | 0 | 26 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 9 | Монгол улсын Ёс зүйн хорооноос болон УА-аас зохион байгуулах Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, семинарт албан хаагчдыг хамруулах | УТ, ОНТ | Хамруулсан албан хаагчийн тоогоор | 0 | 1 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 10 | Сумд, агентлагийн төсөвт байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын | ОНТ | Чадавхжуулсан албан хаагчийн тоогоор | 185 | 200 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах. | | | | | | |
| 11 | Сумд, агентлагийн төсөвт байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын гишүүдийн нэгдсэн уулзалт, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зохион байгуулах. | ОНТ 5 сая | Гүйцэтгэлийн хувиар | 0 | 80 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 12 | Аймгийн нийт төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын гишүүдийн нарийвчилсан судалгааг гаргах | - | Гүйцэтгэлийн хувиар | 0 | 50 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:
АЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Н.БАТТУЯА

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
АЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ЗОРИГТБААТАР

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТ-ЭРДЭНЭ

2025 оны ..... дугаар сарын .....

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
# ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Гүйцэтгэх үйл ажиллагаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| 1 | "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын болон аймгийн түвшинд сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах. | ОНТ | Сургалт, сурталчилгаанд хамрагдсан албан хаагчийн тоогоор | 1,185 | 1,500 | Жилдээ | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, гаргасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх. | - | Гаргасан дүгнэлтийн тоогоор | 3 | 0 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | БТ | Байгууллагын сургалтад хамрагдсан албан хаагчдын тоогоор | 25 | 50 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 4 | Шинээр ажилд орсон ажилтанд чиглүүлэх 8 цагийн сургалтыг ТЗУХ-тэй хамтран зохион байгуулах. | - | Сургалт зохион байгуулсан албан хаагчийн тоогоор | 0 | Шинээр томилогдсон албан хаагчдад | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 5 | Байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох ажлыг ХШҮХ-тэй хамтран зохион байгуулах. | - | Дотоод хяналт шалгалтын тоогоор | 0 | 1 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 6 | Гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хүлээн авч, хянан шалгаж, шийдвэрлэх. | - | Хүлээн авч шийдвэрлэсэн гомдлын тоогоор | 3 | Үүссэн тохиолдолд | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 7 | Аймгийн төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, хуулийг сурталчлан таниулах цахим сургалт, видео хичээл, шторк бэлтгэх. | ОНТ | Бэлтгэсэн цахим сургалт, видео шторкын тоогоор | 0 | 1 | 3 дугаар улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо, АЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба |
| Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах | | | | | | | |
| 8 | Байгууллагын ёс зүйн дэд хороодын гишүүдийн цахим хаягийг бүртгэлжүүлэх | - | Бүртгэлжүүлсэн байгууллагын тоогоор | 0 | 26 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 9 | Монгол улсын Ёс зүйн хорооноос болон УА-аас зохион байгуулах Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, семинарт албан хаагчдыг хамруулах | УТ, ОНТ | Хамруулсан албан хаагчийн тоогоор | 0 | 1 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 10 | Сумд, агентлагийн төсөвт байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын | ОНТ | Чадавхжуулсан албан хаагчийн тоогоор | 185 | 200 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах. | | | | | | |
| 11 | Сумд, агентлагийн төсөвт байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын гишүүдийн нэгдсэн уулзалт, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зохион байгуулах. | ОНТ 5 сая | Гүйцэтгэлийн хувиар | 0 | 80 | 4 дүгээр улиралд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |
| 12 | Аймгийн нийт төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын гишүүдийн нарийвчилсан судалгааг гаргах | - | Гүйцэтгэлийн хувиар | 0 | 50 | Тухайн жилд | Байгууллагын Ёс зүйн дэд хороо |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:
АЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Н.БАТТУЯА

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
АЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ЗОРИГТБААТАР